



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 615

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/142 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Увс аймгийн өмчөөс шилжүүлсэн нийт 3 нэрийн 167,865,727.00 (нэг зуун жаран долоон сая найман зуун жаран таван мянга долоон зуун хорин долоон) төгрөгийн балансын үнэ, 48,878,427.00 (дөчин найман сая найман зуун далан найман мянга дөрвөн зуун хорин долоон) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Увс аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга М.Улаанхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автотээврийн хэрэгслийн эзэмшигчийн эрхийг шилжүүлэн бүртгүүлэх;

2.4. Шилжүүлж буй үл хөдлөх хөрөнгөд хамаарах газар эзэмших эрхийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу Увс аймгийн Онцгой байдлын газрын нэр дээр баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т түрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001109

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны дундажаар сарын өдрийн
615. дугаар тохиолын хавсралт

**УВС АЙМГИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ
УВС АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон он	Хэм- жих нэгж	Тоо хэм- жээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Тэжээлийн агуулах (Наранбулаг суманд)	1972	Ш	1	127,849,110.00	8,861,810.00	118,987,300
2	Хашаа (Наранбулаг суманд)	1972	Ш	1	16,617.00	16,617.00	-
3	Автомашин Донг пэнг, улсын дугаар УВХ 13-59	2008	Ш	1	40,000,000.00	40,000,000.00	-
Нийт дүн					167,865,727.00	48,878,427.00	118,987,300.00
					(Нэг зуун жаран долоон сая найман зуун жаран таван мянга долоон зуун хорин долоон)	(Дөчин найман сая найман зуун далан найман мянга дөрвөн зуун хорин долоон)	(Нэг зуун арван найман сая есөн зуун наян долоон мянга гурван зуун)